



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 154

Номгон

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3, 77.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын нийтийн эзэмшил газрын гудамж талбайн гэрэлтүүлэг, түүний чимэглэлийн эд хөрөнгийг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аас мэргэжлийн байгууллага болох “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-д ажил үүргийн дагуу балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг комисс томилон хүлээлцүүлж, 2017 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117119